



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

20 18 он 12
сарын 04 өдөр

Дугаар ЗГ-1/204

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
М.ЭНХБОЛД ТАНАА

Санал өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасныг үндэслэн Янгугийн Содбаатарыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн хөгжлийн сайдын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай саналыг хуульд заасан журмын дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Асуудлыг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Монгол Улсын Ерөнхий сайд



У.ХҮРЭЛСҮХ

ТАНИЛЦУУЛГА

Засгийн газрын гишүүнийг үүрэгт
ажлаас нь чөлөөлөх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Биеийн эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсноос албан тушаалаас чөлөөлж өгөх тухай хүсэлтээ ... Засгийн газрын гишүүн нь Ерөнхий сайдад өргөн мэдүүлж болно.” гэж, мөн хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д Ерөнхий сайд “Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр ...Засгийн газрын гишүүнийг томилох, албан тушаалаас чөлөөлөх, огцруулах тухай саналаа Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.” гэж тус тус заасан.

Янгугийн Содбаатар нь жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн асуудалд нэр холбогдсон тул ёс зүйн хариуцлага хүлээж, Засгийн газрын гишүүн- Зам, тээврийн хөгжлийн сайдын үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Монгол Улсын Ерөнхий сайдад албан ёсоор гаргасан тул түүнийг Засгийн газрын гишүүн- Зам, тээврийн хөгжлийн сайдын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай саналыг хуульд заасан журмын дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ ТАНАА

2018 оны 11 сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот


Зам, тээврийн хөгжлийн сайд миний бие Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн асуудалд нэр холбогдсонд ёс зүйн хариуцлага хүлээж, Засгийн газрын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайдын үүрэгт албан тушаалаас өөрийн саналаар чөлөөлөгдөх хүсэлтээ хүргүүлж байна.

ЖДҮХС-гийн зээлд миний хамаарал бүхий компани, аж ахуй нэгж хууль журмын дагуу хамрагдаж, уг төсөл амжилттай хэрэгжиж байгаа бөгөөд зээлийг эргүүлэн бүрэн төлсөн болно.

Холбогдох хууль журмын дагуу миний хүсэлтийг шийдвэрлэж өгнө үү.

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН

САЙД



Я.СОДБААТАР



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

2018 оны 12 сарын 03 өдөр

Дугаар Е/34

Төрийн ордон, Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ ТАНАА

Зөвшилцөх саналын тухай

Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн хөгжлийн сайд Янугийн Содбаатарыг хүсэлтийнх нь дагуу үүрэгт ажлаас нь чөлөөлөх асуудлыг зөвшилцөхөөр ирүүлсэн Таны 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн ЗГ-1/197 дугаартай албан бичгийг хүлээн авч холбогдох материалуудтай танилцлаа.

Уг асуудлыг Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтад заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж хэлэлцүүлэх нь зүйтэй байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ



ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА

0000000274

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны ...дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар...

Улаанбаатар
хот

Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39¹ дүгээр зүйлийн 39^{1.2} дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Янгугийн Содбаатарыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн хөгжлийн сайдын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2018 оны ...дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг